



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/1543

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нарийнтээл сумын “Их булаг” гэх газарт хөв цөөрөм байгуулах барилга угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу хөв цөөрмийн барилга, байгууламжийг ашиглалтад оруулах Комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай

2.Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (Б.Мөнхбат)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 1083

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар
сарын 07-ны өдрийн 115 дугаар
захирамжийн хавсралт

**“ИХ БУЛАГ” ХӨВ ЦӨӨРМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Х.Мягмаржав (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын Ус ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

С.Дуламрагчаа (Онги-Таац голын сав газрын захиргааны дарга)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Г.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Онцгой байдлын газрын Гамшигаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Д.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын хяналтын улсын ахлах байцаагч)

Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Ахлах мэргэжилтэн)

Б.Даваацэрэн (аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Б.Сугар (Нарийнтээл сумын Засаг дарга)

Г.Наранбаатар (Нарийнтээл сумын Байгаль орчин хяналтын улсын байцаагч)

Л.Хорлий (Зураг төслийн “Гидро-Фонтан” ХХК-ийн гүйцэтгэх захирал)

Б.Отгонжаргал, А.Анхзаяа (Зураг төслийн “Гидро-фонтан” ХХК-ийн зураг төслийн инженер)

Гүйцэтгэгч: Л.Авирмэд (“Усны барилга” ХХК-ийн захирал) байгууллагын

Төлөөллөл: Э.Төмөрсүх (“Усны барилга” ХХК-ийн инженер)

Нарийн бичгийн дарга: О.Алтанчимэг (Онги-Таац голын сав газрын захиргааны мэргэжилтэн)